

МБМХ бэлчээр тэжээлийн чиглэлээр судалгаа хийдэг оюутан залуусыг чадавхижуулахын тулд хамтран ажиллах, харилцан туршлагаа солилцох боломжийг олгох зорилгоор “Бэлчээрийн залуу судлаачдын клуб”-ыг 2008 онд байгуулсан билээ.

Клубын гишүүд жил бүрийн эхний улиралд “Бэлчээрийн судалгаа-Шинэ үе” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, оролцогчдын илтгэлүүдээр товхимол гаргадаг уламжлалтай болоод 3 жил болж байна.



Энэ удаагийн ээлжит бага хурал 2010 оны 3 дугаар сарын 17нд МБМХ-ны хурлын танхимд болж эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургуулиуд, олон улсын тосол хотолборнуудад бэлчээр, тэжээл, хүрээлэн буй орчны чиглэлээр судалгаа хийдэг 40 гаруй оюутан, судлаачид оролцлоо.

Илтгэлүүдийг судлаачдын болон оюутны ангиллаар хэлэлцүүлэн шалгаруулахад МБМХ-ны судлаач **Д.Бурмаа** “Бэлчээрийн эрвүл мэндэд бэлчээрлэлтээс **взвүлэх нөлөөг бvс бvслvврээр судалсан дvнгээс**” сэдэвт илтгэлээр, оюутны ангилалд ХААИС-ийн Байгалийн Ухааны Сургуулийн магистрант **Н.Хэрлэнтуул** “Тэжээлийн олон наст ургамлыг тарих тохиромжтой **хугацаа**” илтгэлээр тус тус тэргүүлэв.



